



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСҮҮДЭД ЧИГЛЭСЭН СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ





ХӨДӨӨ АЖ АХУЙН БИЗНЕСҮҮДЭД ЧИГЛЭСЭН СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

2024 он

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр тусламжаар энэхүү судалгааг гүйцэтгэх боломжтой болсон. Судалгааны агуулга, тайлан дүгнэлт нь АНУ-ын Засгийн газар эсвэл USAID-ын байр суурийг илэрхийлэхгүй болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь судалгааны ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд судалгааны үр дүнгээс үүдэх аливаа хариуцлагыг хүлээхгүй.

ISBN: 978-99978-925-7-7

АГУУЛГА

ОРШИЛ	5
НЭГ. ХАА-Н САЛБАРЫН СУУРЬ ОРЧИН	7
1.1 ХАА-н салбарын суурь, ойлголт ба нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө	7
1.2. ХАА-г дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчин	11
ХОЁР. ХАА-Н САЛБАРЫН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ	15
2.1. ХАА-н нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал	15
2.2. ХАА-н нэмүү өртгийн сүлжээг сайжруулах санал	21
2.3. ХАА-н салбарын санхүүжилтийн нөхцөл байдал	22
2.3. ХАА-н салбарын санхүүжилтийн боломжит гарц шийдэл	28
ГУРАВ. ХАА-Н БИЗНЕСҮҮДИЙН ТЭЛЭХ ХӨГЖИХ БОЛОМЖУУД	31
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	34
ТАВ. ЗӨВЛӨМЖ	36
Ном зүй	38
Хавсралт 1. Хүнсний ногооны бизнес загварын боломжит хувилбар	39
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1. Судалгааны эмхэтгэлд нэгтгэгдсэн судалгаанууд	6
Зураг 2. Эмхэтгэлийн агуулга	6
Зураг 3. ХАА-н зориулалтаар ашиглаж буй газрын ашиглалт	7
Зураг 4. ЖДҮҮ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр	8
Зураг 5. Чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлт, бизнесийн дэд салбараар	9
Зураг 6. ХАА-г дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчны зураглал	12
Зураг 7. ХАА-н салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөж тулгамдаж буй асуудлууд	14
Зураг 8. Мах махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал	16
Зураг 9. Сүү сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал	18
Зураг 10. Төмс, хүнсний ногооны өртгийн сүлжээний ерөнхий зураглал	19
Зураг 11. Үр тариа (улаан буудай)-ны өртгийн сүлжээний ерөнхий зураглал	21
Зураг 12. ХАА-н салбарын бизнес эрхлэгчдэд олгож буй санхүүжилтийн эх үүсвэр	23
Зураг 13. ХАА-г дэмжих сангаас олгосон зээлийн мэдээлэл	24
Зураг 14. ЖДҮ-г хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээлэл	24
Зураг 15. Банкны салбарын санхүүжилт	26
Зураг 16. МУ-н ХАА-н салбарын санхүүжилтийн зураглал	28
Зураг 17. ХАА-н нэмүү өртгийн санхүүжилтийн сүлжээнд тулгамдаж буй асуудал	30
Зураг 18. Дундын хоршоонд түшиглэсэн бизнес загвар (хүнсний ногоо)	39

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ХАА-н бизнес эрхлэгч нарт тулгамдаж буй асуудлууд

10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДБ	Жижиг, дунд бизнес
ЖДҮҮ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ
ЗГ	Засгийн газар
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ГТ	Газар тариалан
МАА	Мал аж ахуй
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБТҮАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

ОРШИЛ

Хөдөө аж ахуй (ХАА)-н салбарыг мал аж ахуй (МАА), газар тариалан гэсэн ерөнхий 2 зүйлд ангилан хөгжүүлж ирсэн бол сүүлийн жилүүдэд эрчимжсэн, төрөлжсөн цаашлаад технологид суурилсан гэх мэт олон төрлийн үг хэллэгийг ашиглан бүтээгдэхүүний үржил, үр шимд анхаарлаа хандуулаад зогсохгүй бүтээмжийг нэмэгдүүлж ажиллахад дэлхий нийтээр анхаарч ажиллах болжээ. Өөрөөр хэлбэл ерөнхий хэллэгийг ашиглахаас зайлсхийж тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог шинж чанараар ангилан хэрэглэгчдэд хүргэх тогтолцоо улам бүр хөгжиж байна. Дээр нь байгаль цаг уурын нөхцөл байдал, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр, дэлхийн улс орнуудын худалдааны интегралчлал зэргээс шалтгаалан ихэнх улсууд хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээг дотооддоо үйлдвэрлэх, ХАА-н салбарыг дэмжих, технологид суурилан бүтээмжийг нэмэгдүүлж, үр шимийг өсгөхөд төвлөрч цаашлаад боломжит бүтээгдэхүүн, үйлчилгээг бүс нутагтаа худалдаж худалдааны давуу талыг олоход ихээхэн анхаарлаа хандуулах болсон.

Манай улсын хувьд ч хүн ам, нийгэм эдийн засагт ихээхэн чухал салбаруудын нэг нь ХАА салбар юм. Тус салбар нь сүүлийн 10 жилд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 13-14 орчим хувийг бүрдүүлэхээс гадна нийт ажиллагсдын 1/3 орчмыг ажлын байраар хангаж байна. Мөн экспортын 5 орчим хувийг энэхүү салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ эзэлдэг (ҮСХ, 2022). Гэвч сүүлийн жилүүдэд ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчид буурахаас гадна олон төрлийн хүчин зүйлсээс шалтгаалан эдийн засгийн мөчлөгд ихээхэн эмзэг болж байна. Тухайлбал, цаг уурын нөхцөл байдал, ажиллах хүчний хомсдол, ХАА-н салбарт оруулж буй хөрөнгө оруулалт дутмаг, хот хөдөөгийн ялгаатай байдал гэх мэт шалтгаануудын улмаас ХАА-н бизнес эрхлэхэд улам төвөгтэй болж байгаагаас шалтгаалан үйлдвэрлэл буурах, эдийн засагт үзүүлэх нөлөө буурч байна. Иймд төрийн зүгээс сүүлийн жилүүдэд тус салбарт бизнес эрхэлж буй этгээдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг хангахад чиглэсэн дэмжлэг, урамшууллыг явуулахаас гадна олон төрлийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг банкнуудтай хамтран хэрэгжүүлж буй хэдий ч төдийлөн үр ашигтай байхгүй байна. Олон улсын байгууллагуудын зүгээс манай улсын ХАА-н салбарын талаар олон талын судалгаа хийхээс гадна тус салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг чадавхжуулах, мэргэшүүлэхэд анхаарлаа хандуулах, санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсээр ирсэн байдаг.

ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхлэгчид нь ирээдүйн чиг хандлага, технологийн шинэчлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх стратегийн талаар мэдлэг мэдээллийг тасралтгүй авч бүтээмж болон үйлдвэрлэлийн өсөлтөд ихээхэн анхаарч цаашдын үйл ажиллагаандаа тогтмол ашиглах, судалгаанд суурилсан мэдлэг, мэдээллийг олж авахад ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай байна. Нөгөө талаас энэхүү салбарт тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлүүдийн талаар олон төрлийн судалгаануудыг нэгтгэн, тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгч нарт хүргэх, түгээх ажиллагаа дутмаг байгаа нь харагдаж байна.

Иймд энэхүү судалгааны эмхэтгэлийн зорилго нь ХАА-н бизнес эрхлэгч жижиг дунд бизнес (ЖДБ)-үүдэд тулгардаг гол асуудал болох санхүүжилт, нэмүү өртгийн сүлжээний үр өгөөжтэй байдлыг нэмэгдүүлэх, тогтворжуулахад тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх боломж, ХАА-н бизнес эрхлэгчдийн хөгжих боломжууд, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт чиглэн судалгаануудын үр дүн, дүгнэлтийн уялдааг тоймчлон нэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулахад чиглэсэн. Ингэснээр BEST хөтөлбөрийн харилцагчид тэр дундаа ХАА-н ЖДБ эрхлэгч нар хөгжих, зах зээлээ ойлгоход дэмжлэг болох цогц ойлголтыг нэг судалгааны эмхэтгэлээс авах боломжтой болох цаашлаад судалгааны эмхэтгэлд дурдагдах сайн туршлагаудаас суралцах замаар өөрийн үйл ажиллагааг сайжруулах, өргөжүүлэх боломж нээгдэнэ гэдэгт итгэж байна.

Зураг 1. Судалгааны эмхэтгэлд нэгтгэгдсэн судалгаанууд



Судалгааны эмхэтгэлийг боловсруулахдаа Зураг 1-т үзүүлсэнчлэн BEST хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаануудын тоон өгөгдөл мэдээлэл дээр суурилан судалгаануудын хоорондын харилцан хамаарлыг гаргах, уялдаа холбоог нарийн тусгаж харуулахад ихээхэн анхаарч дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны эмхэтгэл нь (i) ХАА-н салбарын суурь орчин ба түүнийг сайжруулах боломжууд, (ii) ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээнд тулгуурлан санхүүжилтийг нэмэгдүүлэх боломж нэмүү өртгийн сүлжээний ойлголтыг сайжруулах нь, (iii) ХАА-н салбарын бизнесүүдийн тэлэх, хөгжих боломжууд түүнд тулгамдаж буй асуудлууд, (iv) дүгнэлт, санал гэсэн үндсэн 4 чиглэлд хувааж, үр дүнг нарийвчлан гаргахыг зорьсон.

Зураг 2. Эмхэтгэлийн агуулга




НЭГ. ХАА-Н САЛБАРЫН СУУРЬ ОРЧИН

1.1 ХАА-н салбарын суурь, ойлголт ба нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө

Сүүлийн 5 жилийн хугацаанд ХАА салбар нь манай улсын эдийн засгийн 13-14 орчим хувийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал нөлөө үзүүлсээр ирсэн. Уламжлалт МАА болон газар тариалан нь манай улсын орон нутгийн үйлдвэрлэлийн 85 орчим хувийг бүрдүүлдэг. ХАА-н гаралтай түүхий эд нь манай улсын экспортын орлогын 5-8 хувийг эзэлдэг бөгөөд цаашлаад манай улсын экспортын нэр төрлийг нэмэгдүүлэх, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүнийг экспортлох, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой салбаруудын нэг юм. Мөн нийт ажиллах хүчний 1/3 нь дан ганц энэхүү салбарт ажилладаг (ҮСХ, 2022). Өөрөөр хэлбэл ХАА-н салбар нь өрхийн аж ахуйгаас эхлээд бүс нутаг, орон нутгийн эдийн засаг цаашлаад улсын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг бөгөөд нийт газар нутгийн 72.9 хувь нь ХАА-н эдэлбэр газар байдаг. Дээр нь ХАА-н салбар нь тээвэр, агуулах болон боловсруулах үйлдвэрлэл тэр дундаа хүнсний үйлдвэрлэлтэй нягт уялдаа холбоотой байдаг тул энэхүү салбарт гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлтүүд нь эргээд бусад салбаруудад нөлөөлж байдаг.

Зураг 3. ХАА-н зориулалтаар ашиглаж буй газрын ашиглалт



Эх сурвалж: ХХААХҮЯ

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ (ЖДҮҮ) эрхлэгчдийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг харж энэхүү салбарын хөгжлийг хэрхэн сайжруулах, нэмэгдүүлэх вэ гэдгийг харж болдог. Тухайлбал 2022 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн 75.7 хувийг ЖДҮҮ эзэлж байгаа

бол нэмэгдэл өртгийн 5.5 хувийг ЖДҮҮ буй болгожээ. Сүүлийн жилүүдэд ЖДҮҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ өсөх хандлагатай байгаа бол ДНБ-д эзлэх хувь харьцангуй тогтвортой байгаа нь харагдаж байна (Зураг 4). Эдийн засгийн салбараар нь авч үзвэл нийт ЖДҮҮ-ийн 4.4 хувь нь л ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд ихэвчлэн өрхийн түвшинд үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 4. ЖДҮҮ эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр



Эх сурвалж: УСХ

ХАА-н салбарын нэмэгдэл өртгийг авч үзвэл нийт нэмэгдэл өртгийн 90 хувийг МАА, 8.9 хувийг газар тариалан, 0.7 хувийг ойн аж ахуй болон ХАА-н бусад салбарууд бүрдүүлдэг. Мөн ХАА-н салбар нь боловсруулах болон тээвэр, агуулахын салбартай нягт уялдаа холбоотой байдаг тул дээрх салбаруудыг хамруулан 2023 онд “ХАА-н салбарын суурь судалгаа”-г түүврийн арга ашиглан гүйцэтгэсэн байдаг. ХАА-н салбарын суурь судалгааны үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан этгээдийн 80.8 хувь нь хоршоо, нөхөрлөл болон компани хэлбэрээр бүртгүүлэн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол ихэнх нь бичил үйлдвэрлэл эрхлэгчид байна. Ихэнх тохиолдолд ХАА-н салбар гэсэн ерөнхий ойлголтын хүрээнд авч үздэг хэдий ч судалгааны үр дүнгээс харахад МАА, газар тариалан, хүнсний боловсруулах үйлдвэрлэл болон тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь нийтдээ 1,013 төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг. Дээр нь салбарын онцлог шинж чанар, үйлдвэрийн хүчин чадал, байршил зэргээс хамааран 7 бизнес эрхлэгч тутмын 2 нь дунджаар 2 төрлийн үйл ажиллагааг хослуулан эрхэлдэг. Түүнчлэн судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 87.2 хувь нь зөвхөн 1 салбарын хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг бол бусад нь 2-4 салбарт үйл ажиллагааг хослуулан эрхэлж байна. Тус салбарын бизнес эрхлэгчид нь жилд дунджаар 103.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг эргэлтэд оруулж, 253.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглаж, 228.9 сая төгрөгийн орлого олдог байна. ХАА-н салбаруудыг хооронд нь харьцуулж үзвэл хүнсний

боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн олж буй орлого нь бусад салбаруудтай харьцуулахад өндөр байгаа нь илүү их нэмүү өртөг шингээж эцсийн бүтээгдэхүүн болж хэрэглэгчдэд хүрч буйтай холбоотой. Мөн МАА бизнес эрхэлж буй бизнес эрхлэгчдийн орлого газар тариалан болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс бага байна. Газар нутгийн байршил, үйл ажиллагааны онцлог, бүтээгдэхүүний харьцангуй давуу тал зэргээс хамаарч дан ганц МАА эсхүл газар тариалан гэхээс илүүтэйгээр жижиг хэмжээний хүнсний боловсруулах үйлдвэр, тээвэр болон агуулахын үйлчилгээ зэргийг аль нэгтэй хослуулах нь бизнесийн үйл ажиллагаанд ашигтай болох нь харагдаж байна.

Тус салбарт бизнес эрхлэгчдийн 48 хувь нь байнгын ажлын байраар 52 хувь түр ажлын байраар ажилчдаа хангадаг. Байнгын болон түр ажлын байранд ажиллаж буй хүмүүсийн хүйсийн харьцаа тэнцүү байна. Бизнес эрхлэгчдийн 8.8 хувь нь өмнөх жилтэй харьцуулахад ажиллагсдын тоог өсгөсөн бол 10.6 хувь нь ажиллагсдын тоог бууруулжээ. Байнгын болон түр ажлын байранд ажиллуулахдаа нийт бизнес эрхлэгчдийн 37.7 хувь нь гэрээ байгуулдаг бол 32.8 хувь нь зөвхөн байнгын ажлын байранд ажиллах хүмүүстэй гэрээ байгуулж ажилладаг. Нийт судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын дундаж түвшин 76.9 хувь бөгөөд МАА болон газар тариалан эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашигладаг болох нь харагдаж байна. Харин судалгаанд хамрагсдын 65.8 хувь нь нөөцийн бүртгэл, бараа материал, нөөцийн захиалгыг удирдлага шийддэг бол нөөцийг төрлөөр нь ангилах, бүлэглэх систем хөтөлдөггүй байна. Ажилчдын тоо их, төлөвлөлт судалгаа хийдэг, тодорхой хэмжээнд техник, технологийг ашиглаж буй бизнес эрхлэгчдийн хувьд тодорхой хэмжээнд агуулах болон нөөцийн бүртгэл, бизнесийн үйл ажиллагааны зардал, орлогыг тооцон бизнесийн үйл ажиллагааг цаашид тасралтгүй авч явах боломжтой байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан ХАА-н бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу 96 хувь нь өөрийн бизнест чанарын баталгаажуулалт, олон улсын стандарт (ISO) нэвтрүүлээгүй бөгөөд энэ талын мэдээлэл хайх, нэвтрүүлэх талаар судалсан байдал хангалтгүй байна¹.

Зураг 5. Чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлт, бизнесийн дэд салбараар



ISO 45001
ISO 9001:2015
ISO 14001:2015



ISO 45001 - 1 бизнес
ISO 9001:2015 - 2 бизнес
ISO 14001:2015 - 2 бизнес



ISO 45001 - 3 бизнес
ISO 9001:2015 - 12 бизнес
ISO 14001:2015 - 6 бизнес



ISO 45001
ISO 9001:2015 - 1 бизнес
ISO 14001:2015

Эх сурвалж: ХАА-н суурь судалгаа, 2023

1 ISO 45001, ISO 9001:2015, ISO 14001:2015 гэсэн стандартуудыг нэвтрүүлсэн байна.

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь чанарын стандарт нэвтрүүлээгүй байгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр хүнд, зах зээлд эрэлттэй байхад ихээхэн нөлөөлж байж болзошгүй юм. Дээр нь ихэнх тохиолдолд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахтай холбоотой гэрээ хэлцлийг хийхэд өөрийн биеэр очиж уулзах, сошиал медиа ашиглах болон хурал цуглаан, үзэсгэлэн худалдаанд оролцох гэх мэтчилэн аргуудыг түлхүү ашиглаж байна.

Сүүлийн жилүүдэд бүхий л салбар техник, технологийн нөлөөгөөр асар хурдацтай хувьсан өөрчлөгдөх болжээ. ХАА-н салбарын хувьд ч мөн адил техник, технологийн шинэчлэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, бүтээмжид ихээхэн нөлөөлөхөөс гадна сүүлийн жилүүдэд ажиллах хүчний хомсдол өндөр байгаа нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдээс одоо тулгамдаж буй болон ирээдүйн хэрэгцээ шаардлагын талаар асуухад санхүүжилт, технологийн шинэчлэлт болон хүний нөөцийн дутагдал өндөр байгаа талаар дурджээ.

Хүснэгт 1. ХАА-н бизнес эрхлэгч нарт тулгамдаж буй асуудлууд

Санхүүжилт	 83%	Тус салбарт бизнес эрхлэгчдийн 83 хувь нь санхүүжилтийн хэрэгцээтэй тулгардаг. Мөн бизнес эрхлэгчдийн 46 хувь нь ойрын хугацаанд зээл авахаар төлөвлөж байгаа бөгөөд дунджаар 223.7 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байдаг. Банк, орон нутгийн сангууд, олон улсын төсөл хөтөлбөрүүдээс санхүүжилт авахаар хүсэлтээ илэрхийлж байжээ. Ингэхдээ ихэвчлэн 2-с дээш байгууллагад санхүүжилтийн хүсэлт илгээдэг.
Техник, тоног төхөөрөмж	 70%	Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн процессыг хялбарчлах, үйлдвэрлэлийн чадамжийг нэмэгдүүлэх орчин үеийн шинэлэг техник, тоног төхөөрөмжийн эрэлт хэрэгцээ өндөр байна. Нөгөө талдаа ХАА-н салбарын техник, тоног төхөөрөмжийн үнэ бусад салбартай харьцуулахад өртөг өндөр байдаг тул өөрийн хөрөнгөөр худалдан авах боломжгүй байдалд хүргэдэг тул түүнийг худалдан авах санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөр байгаа нь харагдаж байна.
Хүний нөөц	 36%	Ажил олгогч тал болон ажиллах хүчний хооронд цалин хөлс, ур чадвар дээр ойлголтын зөрүүтэй байдал үүсдэгээс шалтгаалан тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийн дутагдалд хүргэж байна. Энэхүү зөрүүтэй байдлыг арилгахад ажилчдыг сургах эсхүл мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, тусламж авах хэрэгцээ шаардлага үүсэж буй талаар дурджээ.
Уур амьсгалын өөрчлөлт	 65%	Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 78 хувь нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт нь бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд эрсдэл учруулж буйг дурджээ. Энэхүү эрсдэлийг шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинээр бизнесээ төлөвлөх, бизнесийн загвараа өөрчлөх боломж гэж харж буй бизнес эрхлэгчид олон байна. Дээр нь цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, түүний эсрэг арга хэмжээ авах, зохистой дадлын талаар сургалт мэдээллээр хангаж өгвөл бизнесийн үйл ажиллагаанд хэрэгжүүлээд явах бүрэн боломжтой.

Эх сурвалж: ХАА-н суурь судалгаа, 2023

ХАА-н зориулалтаар ашиглаж буй эдэлбэр газрыг зүй зохистой ашиглахгүй байх, техник технологийг шийдлийг нэвтрүүлж хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж чадахгүй байхаас гадна байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалан бэлчээрийн доройтол ихээхэн нэмэгдэж ХАА-н салбарын нэмэгдэл өртөг төдийлөн өсөхгүй байх үндсэн шалтгаан болж байна. Иймд дээрх салбарын хөгжлийг хурдасгах, технологийн шийдлийг хурдацтай нэвтрүүлэх, ажиллах хүчний хомсдолыг техникийн тусламжтайгаар шийдвэрлэхээс гадна цахилгаан, зам болон усны асуудлыг цогцоор шийдвэрлэх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон төрлийн арга хэрэгслийг ашиглах бодлогын арга хэмжээг шат дараатайгаар авах зайлшгүй нөхцөл байдал ирсэн.

1.2. ХАА-г дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчин

МУ-ын хувьд сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспорт хурдацтай нэмэгдэж, цөөн тооны эрдэс бүтээгдэхүүний экспортоос шууд хамааралтай буюу тэдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээлдээрх үнийн өөрчлөлтөөс хамаарсан эдийн засгийн эмзэг байдал улам бүр нэмэгдсэн. Иймд нэг салбараас хамаарал бүхий эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, зарим салбаруудыг бодлогоор дэмжих зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Нөгөө талаас дэлхий нийтээр эрүүл хүнс хэрэглэх, байгаль экологид ээлттэй үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулах, ядуурлыг бууруулах, ХАА-н өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ногоон эдийн засгийг дэмжиж ажиллах тал дээр нэлээдгүй анхаарлаа хандуулах болсон.

ХАА-н бодлого, зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн яам нь тодорхойлж, холбогдох хуулийн хүрээнд арга хэмжээнүүдийг авч ажиллаж ирсэн хэдий ч санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжүүлэх нөхцөл, санхүүжилтийн хүртээмжтэй байдал зэргийг бүхэлд нь авч бодлого, зохицуулалтыг хийж байсан тохиолдол цөөхөн. УИХ-аас хамгийн анхны ХАА-н чиглэлийн бодлогын баримт бичгийг 1996 онд боловсруулж төрөөс баримтлах бодлогын чиг баримжааг гаргаж байсан бол харьяа яам нь төрийн бодлого, зохицуулалтыг хийж, шаардлагатай арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлсээр иржээ. Тухайлбал “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд 2008 онд Атрын III аяныг зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш анх зохион байгуулж хөтөлбөрийн хүрээнд ХАА-н салбар тэр дундаа тариалан эрхлэгчид удаан хугацаанд хэрэглэсэн техник, технологийг шинэчлэн, тодорхой хэмжээнд технологийн шийдлийг салбартаа нэвтрүүлж, бүтээгдэхүүний гарцын хэмжээг нэмэгдүүлж ажилласан байдаг. ХАА-г бодлого, зохицуулалтын хүрээнд дэмжихээр боловсруулагдсан 80 гаруй хууль, дүрэм, журам үйлчилж байна.

Зураг 6. ХАА-г дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчны зураглал



Эх сурвалж: ХАА-н салбарын санхүүжилтийн стратегийг загварчлах нь
судалгааны үр дүн

Дээрх зураг 6-д хууль, эрх зүйн зохицуулалт нь салбарын оролцогчдыг тодорхойлж, эрхлэх үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохицуулалтыг тусгаж өгөхөөс гадна ХАА-н салбарыг дэмжиж ажиллах институтийн оролцоо, үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлж өгөхийг зорьсон байгаа нь салбар хоорондын уялдаа холбоог хангах, төрийн байгууллагуудын давхардлыг арилгах, хүнд суртлыг бууруулах, өрсөлдөх чадвартай ХАА-н бүтээгдэхүүнийг дэмжихэд чиглэсэн орчин бүрдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж буйг харуулж байна. Гэвч технологийн дэвшлийг хэрхэн нэвтрүүлэх, нэн шаардлагатай хөрөнгийн санхүүжилтийг хэрхэх хийх, санхүүжилтийн ямар арга хэрэгсэл ашиглах, институт хоорондын уялдааг хэрхэн хангах, салбарын эдийн засгийн үр өгөөж, эрсдэлийг хэрхэн тооцоолох талаар нарийн тусгаж өгөөгүй байгаа нь үйл ажиллагаа эрхэлж буй этгээдэд тодорхой бус байдлыг үүсгэж байна. Дээр нь салбарын тоон мэдээлэл дутмаг, салбар хоорондын тоон мэдээлэл хомс нь байгаа нь тодорхой бус байдлыг үүсгэдэг.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд эрчимтэй яригдаж буй ногоон шилжилт, байгаль экологид ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, уур амьсгалын өөрчлөлт зэргээс шалтгаалан зарим ХАА-н бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бодлогоор дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсэж буйгаас гадна ХАА-н бүтээгдэхүүнийг эрүүл аюулгүй үйлдвэрлэж олон улсад өрсөлдөх, экспортын баримжаатай болгох, эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхэд түс салбарт инновацыг дэмжсэн, санхүүжилтийн

олон төрлийн арга хэрэгслийг оновчтой ашиглах, хүнсний аюулгүй байдалтай холбоотой зарим төрлийн хүнсний стандарт аргачлалыг нэвтрүүлэх, дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүйн орчин дутмаг байна.

ХАА-г дэмжих, ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих, аюулгүй хүнс, байгаль, орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ХАА-н бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиг баримжааг 2020 онд батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улс (МУ)-ын урт хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлж өгсөн. Түүнчлэн тус бодлогын баримт бичигт хөдөлмөрийн нөөцийг зөв зохистой ашиглах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шинжлэх ухаан, амьдрах орчин, эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг дэмжих зэрэг хэд хэдэн чиглэлийн хүрээнд ХАА салбарыг дэмжихээр тусгаж өгсөн.² Үүний зэрэгцээ ерөнхийлөгчийн санаачилгаар 2022-2027 онд хэрэгжүүлэх “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг орон даяар эхлүүлж хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа органик хүнс экспортлогч улс болохоор зорилт тавин ажиллаж байна (УИХ, 2020).

Засгийн газар (ЗГ)-ын зүгээс дээрх урт хугацааны бодлогын арга хэмжээ, үндэсний хөдөлгөөн зэрэгтэй уялдуулан “Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө 2024”-ийг батлуулан экспортыг нэмэгдүүлэхэд тэргүүлэх чиглэлээр ХАА-н салбарыг нэрлэн энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүхий л шатанд нь дэмжиж ажиллахаар тусгажээ. Ийнхүү төрөөс баримталж буй бүхий л төрлийн бодлогын баримт бичиг, зарим төрлийн хууль, эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээнд ХАА-г дэмжиж ажиллахаар төлөвлөөд байгаа хэдий ч хамгийн чухал хэсэг болох санхүүжилтийг хэрхэн нэмэгдүүлэх, санхүүжилтийг хэрхэн үр ашигтай олгох, санхүүжилтэд хэрхэн талуудыг татан оролцуулах талаар нарийн тусгаж өгөөгүй. Өөрөөр хэлбэл төрөөс хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ нь ихэвчлэн дэмжлэгийн шинж чанартай буюу мөнгөн урамшуулал олгох, хүүгийн татаас олгох, эсхүл мөнгөн бус дэмжлэгийн арга хэмжээг авч иржээ. Эдгээр дэмжлэгүүд нь цаг үеийн шинж чанартай, уялдаа холбоо сул зэргээс шалтгаалан дорвитой үр дүнд хүрэхгүй, ХАА-н үйлдвэрлэлийг урт хугацаандаа нэмэгдүүлэх арга хэрэгсэл биш байсан нь харагдаж байна.

² “Алсын хараа – 2050” ур хугацааны хөгжлийн бодлогод ХАА-н салбарыг дэмжих талаар хэсэг, бүлгүүдэд тусгасан байдаг.

Зураг 7. ХАА-н салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөж тулгамдаж буй асуудлууд



Эх сурвалж: ХАА-н суурь судалгаа, ярилцлагын үр дүнгээс

ХАА-н бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах агуулахад шаардлагатай логиستيкийн дэд бүтэц, эцсийн бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдэд хүргэх хүнсний үйлдвэрүүд, түүнийг дагасан дэд бүтцийн уялдаа холбоог бүхэлд нь хангасан тогтолцоог дэмжсэн хууль, эрх зүйн орчин дутмаг байгаа нь хэд хэдэн судалгааны үр дүнд харагдаж байна.

ХОЁР. ХАА-Н САЛБАРЫН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ОЙЛГОЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ

2.1. ХАА-н нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал, тулгамдаж буй асуудал


Тайлангийн энэ хэсэгт ХАА-н салбарын дэд салбар болох МАА, ГТ-ийн нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал, гол хүндрэл бэрхшээлүүд, даван туулах боломжийн тухай харуулах болно. МАА-н бүтээгдэхүүнээс мах, махан бүтээгдэхүүн болон сүү сүүн бүтээгдэхүүнийг сонгон авч нэмүү өртгийн сүлжээний зураглалыг гаргахад мах махан бүтээгдэхүүний зах зээлд дундын борлуулагч/зууч буюу ченжүүдийн оролцоо өндөр, бүтээгдэхүүний үнэ бөөний болон жижиглэнгийн худалдаачдаас хамааралтай байдаг нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа. Харин сүү, сүүн бүтээгдэхүүний хувьд түүхий эд цуглуулах систем төвийн бүсээр харьцангуй сайн хөгжиж илүү зах зээлийн жамаар эцсийн бүтээгдэхүүнүүд хэрэглэгчид хүрч байна. ГТ-н салбар ялангуяа төмс, хүнсний ногооны өртгийн сүлжээнд дундын зуучлагчийн нөлөө өндөр бол үр тарианы (улаан буудай) зах зээл илүү төрийн зохицуулалттай буюу тариаланчид хямд үнээр буудайн үр тариалж эргээгээд буудайгаа ХААДС, улсын нөөцөд нийлүүлдэг байна (ХАА-н суурь судалгаа, 2023). Ингээд бүтээгдэхүүн тус бүрээр нэмүү өртгийн сүлжээний зураглалыг тайлбарлая.

а) МАА-н гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал

Мах махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал

Мах, махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ нь (1) маллагаа, нядалгаа, (2) тээвэрлэх, борлуулах, туувар, (3) боловсруулах, ангилах, савлах, (4) тээвэрлэх, хадгалах, (5) борлуулах гэсэн ерөнхий таван үйл ажиллагаанаас бүрддэг байна (ХАА-н суурь судалгаа, 2023). Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын үе шатаар нь харвал 1-5 хүртэлх үйл явцыг үйлдвэрлэлийн үе шат, 1-3 хүртэлх үйл явцыг завсрын үе шат, 4-5 хүртэлхийг маркетингийн үе шат гэж ойлгож болно.

Зураг 8. Мах махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НҮТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018

Өртгийн сүлжээний зураглалыг тайлбарлахад малчдын гар дээрээс гарч буй мах нь малын зах, хүнсний зах, бөөний худалдааны төв болон жижиглэнгийн худалдаагаар дамжиж Улаанбаатар хот болон хүн ам төвлөрсөн суурин газрын хэрэглэгчид, ресторан, зоогийн газруудад нийлүүлэгдэж байна. Дундын зуучлагчид малчдаас хүлээн авсан мал, махныхаа тодорхой хэсгийг боловсруулах үйлдвэр, хиамны үйлдвэрүүдэд нийлүүлж, үлдсэн хэсгийг Улаанбаатар хотын болон томоохон хот, суурин газруудын мал, махны захад нийлүүлдэг. Малчдаас болон дундын зуучлагчдаас гарч буй мах боловсруулалт хийгдээгүй буюу түүхий хэлбэрээр борлуулагддаг бол боловсруулах үйлдвэрүүдээр дамжиж буй мах бүрэн болон хагас боловсруулалт хийгдэж, бөөний болон жижиглэнгийн худалдаагаар дамжиж дотоодын, экспортын худалдаагаар дамжин гадаад зах зээлд эцсийн хэрэглэгчдэд хүрч байна (Зураг 8).

Тулгамдаж буй асуудал

- Бэлчээрийн доройтол, усны нөөц хомсдол, малын өвчлөл, тэжээлийн дутагдал, хөдөлмөрийн нөөц дутмаг байгаа нь мал аж ахуй эрхлэхэд хамгийн ихээр тулгамдаж буй асуудал болж байна.
- Дэд бүтэц, тээвэр логистиктой холбоотой асуудлууд хэвээр байгаа нь нийлүүлэлтийн аль аль шатандаа хүндрэлүүдийг бий болгосоор байна. Тухайлбал, боловсруулах үйлдвэрлэлийн техник технологийн хоцрогдол, боловсруулсан бүтээгдэхүүний

тээвэр, хүргэлт, чанарын шаардлага хангасан агуулах зоорины дутагдлаас үүдэн бүтээгдэхүүний чанар стандартын асуудалд сөргөөр нөлөөлдөг.

- Чанар стандартын баталгаажуулалтыг олгодог мэргэжлийн байгууллагуудын оролцоог сайжруулж, мах бэлтгэн нийлүүлэгч жижиг дунд бизнес эрхлэгчдийн мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна.
- Нийлүүлэлтийн сүлжээний өртгийн тооцооллыг хийж, аль үе шатанд хамгийн их нэмүү өртөг шингэж буйг тодорхойлох. Мал аж ахуйн бизнес эрхлэгчдэд өртгийн сүлжээнд оролцох, тасралтгүй нийлүүлэлт хийх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч ажиллах.

Сүү, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-наас Хүнсний тухай хуулийн 8.3, 8.5 дахь заалтыг үндэслэн журам³ баталсан ба энэ журмаар малчид болон эрчимжсэн МАА эрхлэгчдийг урамшуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах юм. Ингэж зохицуулалт хийснээр эрчимжсэн МАА эрхлэгчдийн бэлтгэн нийлүүлсэн түүхий сүүнд урамшуулал олгох эрхзүйн орчин бүрдэж, сүү боловсруулах үйлдвэрүүд хэрэглэгчдийг үйлдвэрийн аргаар боловсруулсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сүүгээр хангах, улирлын хамаарлыг бууруулах, дотоодын хэрэгцээг тогтвортой хүртээмжтэй, хангах нөхцөл бүрджээ.

Сүү, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдыг бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгч гэж ангилж болно. Фермүүдийн бэлтгэсэн сүүг ихэвчлэн сүү боловсруулах үйлдвэрүүд гэрээний үндсэн дээр худалдан авдаг бол малчин өрхийн бэлтгэсэн сүүний багахан хувь нь сүү боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэгддэг байна. Сүүний үйлдвэрүүд сүүг худалдан авахдаа дулааны улиралд өөрсдийн хөргөх цех дээр хүлээн авдаг бол хүйтний улиралд шууд цистернээр цуглуулж авдаг. Зарим тохиолдолд зуучлагчдаас худалдан авалт хийдэг байна. Малчин өрхөөс зах зээлд нийлүүлэгдэж байгаа сүү нь түүхий сүүгээр нийлүүлэгдэхээс гадна уламжлалт аргаар боловсруулсан сүүн бүтээгдэхүүн хэлбэрээр шууд болон борлуулагч/зуучлагчдаар дамжин нийлүүлэгдэж байна (Зураг 9).

Бэлтгэн нийлүүлэгч нь улсын хэмжээний 188.6 мянган малчин өрх /2021 оны тоо/, үүний дотор 3,035 сүүний чиглэлийн үхрийн ферм /2021 оны тоо/ юм. Бэлтгэн нийлүүлэгчид нь түүхий сүүг өрхийн хэрэгцээнд болон зах зээл дээр нийлүүлж байна. Улсын хэмжээнд бэлтгэж байгаа 859.0 сая литр сүүний 88.0 сая литрийг сүүний чиглэлийн үхрийн фермүүд, 771.2 сая литр сүүг малчин өрхүүд бэлтгэсэн ба үүний 31.7 сая литр түүхий сүүг үйлдвэрт нийлүүлсэн байна.

3 “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам”- Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор батлуулсан.

Зураг 9. Сүү сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НҮТББ, “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь”, 2018

Тулгамдаж буй асуудал

- Бэлчээрийн доройтол, усны нөөц хомсдол, малын өвчлөл, тэжээлийн дутагдлаас болж мал давжаарч, уургийн дутагдал, дархлааны сулралд ордог бөгөөд энэ нь сүүний гарц чанарт нөлөөлдөг.
- Хүний нөөц болон хөрөнгө оруулалтын дутагдал нь **эрчимжсэн МАА эрхэлж буй бизнес эрхлэгчдийн бүтээмжид хамгийн ихээр нөлөөлж байна.**
- Мал эмнэлгийн үйлчилгээ чанар хүртээмж муу байдаг нь малын өвчлөл буурахгүй байх улмаар сүүний гарц чанарт нөлөөлдөг ажээ. Малын өвчлөл буурахгүй байх нь олон улсад бүтээгдэхүүнээ экспортлоход тарифын бус худалдааны хязгаарлалтуудад орж, сүү сүүн бүтээгдэхүүний экспортод сөргөөр нөлөөлдөг байна.
- Дэд бүтэц буюу сүү цуглуулах, боловсруулах үйлдвэрүүд хомс байгаа нь ихэнх малчид бүтээгдэхүүнээ түүхийгээр нь эсвэл уламжлалт аргаар боловсруулан, хямд үнээр зах зээлд нийлүүлэхээс өөр аргагүйд хүрдэг ба энэ нь малчид буюу анхан шатны үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний үнэ цэнийг авч чадахгүйд хүрдэг. Дээр нь алслагдсан бүс нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чанарын шаардлага хангасан үйлдвэр, хадгалах байгууламж байхгүйгээс шалтгаалан уламжлалт аргаар сүүн, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах, эсхүл түүхийгээр зах зээлд нийлүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдалтай байна.
- Тээвэр, логиستيкийн **хүндрэлтэй байдал болон чанар, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл хомс байна.**


б) Газар тариалангийн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний зураглал

Төмс, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний ерөнхий зураглал

Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний зураглалыг ХАА-н бизнесийн нэмүү өртгийн судалгааны үр дүн болон ХАА-н суурь судалгааны үр дүнг нэгтгэн зурлаа. Хүнсний ногооны үйлдвэрлэлд өрхийн түвшний тариаланчид голлох үүргийг гүйцэтгэдэг ба төмс, хүнсний ногооны бүтээгдэхүүнүүд олон шат дамжлагатайгаар эцсийн хэрэглэгч нарт хүрдэг. Орц, хүнсний ногооны анхан шатны үйлдвэрлэл, хүнсний ногооны боловсруулалт, зах зээл/хуваарилалт, эцсийн хэрэглэгч гэсэн таван ерөнхий дамжлагаар хүрч байна (Зураг 10).

Анхан шатны боловсруулалт хийдэг дундын хоршоо болон өрхийн түвшний боловсруулах цех нэмүү өртгийн сүлжээнд оролцож байгаа нь бүс нутгаас үл хамааран орон нутагт нэмүү өртөг шингэсэн хүнсний ногооны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой нь харагдаж байна. Дээр нь хүнсний ногооны бусад ХАА-н бүтээгдэхүүнээс ялгаатай нь боловсруулах үйлдвэр илүү хөгжсөн. Нэмүү өртгийн сүлжээнд оролцож буй байдлыг авч үзвэл бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үе шатанд буюу боловсруулах үед илүү өндөр өртөг шингэдэг, нэгж бүтээгдэхүүний хувь өндөр байна. Дараагийн гол үр өгөөж хүртэж буй оролцогч нь зах зээлд борлуулах үе шатанд оролцогчид байгаа бол хамгийн бага үр өгөөж хүртэж буй оролцогчид нь хүнсний ногооны тариалан эрхэлж буй өрхүүд, анхан шатны хоршоо, дундын хоршоо болон ААН байна.

Зураг 10. Төмс, хүнсний ногооны өртгийн сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь, 2023

Тулгамдаж буй асуудал:

- Санхүүжилт олох боломж хомс, хүртээмж муу байгаа нь


үйлдвэрлэлийг өргөжүүлэх, шинэ техник технологийг ашиглах, цаашлаад тасралтгүй үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг.

- **Техник тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй** байдал нь тариалалт, хураалтын үеийн төлөвлөгөөт ажлуудыг өөрчилдөг ба улмаар энэ нь өрхийн болон анхан шатны хоршоодын борлуулалтад нөлөөлдөг.
- Чанар стандарт, норм технологийн дагуух тариалалт, үр бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээ болон эх үүсвэрт хяналт тавьдаг нэгдсэн тогтолцоо үүсээгүй байгаа нь бүтээгдэхүүний чанарыг тогтоох, баталгаажуулахад хүндрэл үүсгэдэг.
- Агуулах зоорины дутагдалтай байдал нь тогтвортой, тасралтгүй нийлүүлэлт хийх боломжийг хязгаарладаг. Дээр нь тээврийн зардал өндөр байгаа нь ургац хураалтын үед л нэг удаагийн нийлүүлэлт хийхээс өөр сонголтгүй болгож байна.
- **Хоорондын итгэлцэл сул.** Өрхийн бизнес эрхлэгчдийн хувьд хамтраад, хоршоод ажиллах сонирхол өндөр хэдий ч хоорондын итгэл сул дээр нь хэрхэн хамтарч ямар төрлийн зардлыг хуваалцах талаар мэдлэг дутмаг.
- **Борлуулалт, маркетинг, менежментийг** хэрхэн хийх талаар мэдлэг дутмаг. Дээр нь мэргэжлийн хүмүүсийг ажиллуулахад өртөг өндөр байгаа нь дээрх чиглэлийн хүмүүсийг авч ажиллуулах сонирхлыг төрүүлэхгүй байна.

а) Үр тариа, тэжээлийн нэмүү өртгийн сүлжээний зураглал

Үр тариа, тэжээлийн тариалалтын 90 орчим хувийг улаан буудай эзэлдэг. Сүүлийн арван жилийн дунджаар жилдээ 370 орчим мянган тонн улаан буудай хурааж авсан бөгөөд үүнийг 100 хувь дотоодын хэрэгцээнд зарцуулжээ (Battulga Jamsranjav and Buyannemekh Puntsagdorj, 2021). Үр тариа (улаан буудай)-н зах зээлд оролцогч талууд МУЗГ буюу ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйг дэмжих сан (ХААДС), гурил үйлдвэрлэгчид, тариалан эрхлэгчид, мэргэжлийн холбоодоос бүрдэж байна. Тариаланчид үр тариагаа 100 хувь дотооддоо нийлүүлдэг ба хураан авсан тариагаа гурил үйлдвэрлэгч, ХААДС, болон спирт, тэжээлийн үйлдвэртэй харилцан тохиролцож борлуулалт хийдэг (Зураг 11).

Зураг 11. Үр тариа (улаан буудай)-ны өртгийн сүлжээний ерөнхий зураглал



Эх сурвалж: БОХААЭЗХ НҮТББ, "ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт: Үнэ цэний сүлжээтэй уялдах нь", 2018

Тулгамдаж буй асуудал

- Уур амьсгалын өөрчлөлт, газарзүйн байршил тэдгээрийн онцлог зэрэг байгаль цаг ууртай холбоотой хүчин зүйлсээс хамааран тариалалтын технологийн цаг хугацаанд нөлөөлөн ургацын гарц, чанарт сөргөөр нөлөөлж байна. Үүнээс улбаалан хөрсний доройтол ихсэж байгаа нь тариаланчдын хувьд ихээхэн хүндрэлийг бий болгож байна. Дээр нь хөрс бордолт, сэлгэн тариалалт хангалттай хийдэггүй, ургамал хамгааллын арга хэмжээ маш бага авдаг.
- Дэд бүтцийн буюу тээвэр логистикийн асуудал нь үр тариа тариалж буй иргэд, аж ахуй нэгжүүдэд тулгамдаж байна. Тухайлбал агуулах савны хүрэлцээ дутмаг байгаа нь тээврийн зардлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг ба түүнчлэн үр тариа нийлүүлэхэд шаардлага хангасан тээврийн хэрэгслүүд ховор байна.
- Чанар стандартын нэгдсэн лаборатори байгууллага байхгүй байгаа нь зах зээлд нийлүүлж буй үр тарианы чанар ангилал нь харьцангуй адил байгаа нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарт асуудал болж байна.
- Төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого төсөл хөтөлбөрүүд, баримт бичгүүд улаан буудайнд чиглэсэн байгаа нь бусад төрлийн үр тариа, тэжээлийн таримлуудын зах зээлийг дэмжих хөгжүүлэх бодлого хангалтгүй байна.

2.2. ХАА-н нэмүү өртгийн сүлжээг сайжруулах санал

ХАА-н гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнүүдийн нэмүү өртгийн сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх нь бүс нутагт төдийгүй улс орны эдийн засаг, хүн амын хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын

байр зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л төвшинд таатай нөхцөлийг бий болгох боломжтой юм. Өмнөх хэсэгт ХАА-н салбарт ашиглагдаж буй нэмүү өртгийн сүлжээний зураглалыг үйл ажиллагааны онцлог бүрд харуулан түүнд тулгамдаж буй асуудлуудыг харуулсан бол энэ хэсэгт нэгдсэн байдлаар дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх цаашлаад хэрхэн нэмүү өртгийн сүлжээг сайжруулах боломжтой талаар авч үзье.


- Анхдагч болон дундын хоршоод хэрхэн нэгдэж нийлэх, хэрхэн зардлаа бууруулах, үр ашгийг хэрхэн нэмэгдүүлэх талаар менежментийн зөвлөгөө өгөх. Борлуулалт тал дээр маркетинг, менежментийг зөв зохистой ашиглах. Мөн тодорхой хэмжээнд хоршоод агуулах, тээвэрлэлтийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх.
- Бүс нутгийн хэмжээнд агуулах болон тээвэр, логистикийг шийдвэрлэх. ХАА-н анхдагч бүтээгдэхүүн гарахаас эхлээд дамжлага шат бүрд тохирсон агуулах болон тээвэрлэлтийг олон улсын стандартад нийцсэн байдлаар зохицуулахад төр болон хувийн хэвшил хамтран ажиллахад анхаарлаа хандуулах.
- Техник, технологи болон хүний нөөцийн дутагдлыг арилгахад чиглэсэн хамтарсан хөрөнгө оруулалтыг хийх. Цаашлаад тухайн технологийн ашиглалтай холбоотой зардлыг хуваалцах, хүчин чадлыг бүрэн хэмжээгээр ашиглахад анхаарлаа хандуулах.
- ХАА-н бизнес эрхлэгчээс эцсийн хэрэглэгч хүртэлх бүхий л дамжлагыг харуулсан нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, тоон мэдээллийг ашиглах. Ийнхүү нэгдсэн тоон мэдээллийг ашиглах нь нэг талд борлуулагч/зуучдын борлуулалтын хэт их давуу тал авсан байдлыг бууруулж, ХАА-н бизнес эрхлэгч болон үйлдвэрлэгчдийн үр ашиг нэмэгдэх боломжтой.
- ХАА-н бизнес эрхлэгч нарт уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гарч буй эрсдэлийг хэрхэн боломж болгон ашиглах боломжтой талаарх мэдээлэл, мэдлэг түгээх.
- ХАА-н бизнес эрхлэгч нарт гэрээний үүрэг болон бусад хууль, тогтоомжийн талаарх мэдлэгийг олгох. Нэгэнт нэмүү өртгийн сүлжээний нэг хэсэг болж буй бол хэрхэн тогтвортой, тасралтгүй нийлүүлэлт хийх талаар мэдлэгийг олгох.
- Эцэст нь нэмүү өртгийн сүлжээний мэдээлэлд тулгуурлан тухайн сүлжээнд оролцогч ХАА-н бизнес эрхлэгч нарт санхүүжилтийн олон төрлийн боломжийг буй болгох замаар техник, технологийн шинэчлэл, хүний нөөцийн дутагдалтай байдлыг зэргийг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах. Дараагийн бүлэгт хэрхэн нэмүү өртгийн сүлжээнд тулгуурлан үр ашигтай, хүртээмжтэй санхүүжилт хийх боломжтой талаар дурдах болно.

2.3. ХАА-н салбарын санхүүжилтийн нөхцөл байдал

Дэлхийн ихэнх улсуудад ХАА-н салбар нь тухайн улсын чухал салбаруудын нэг байдаг тул тус салбарт бизнес эрхэлж буй этгээдийг дэмжихэд чиглэсэн олон төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй, үр ашигтай байхад чиглэсэн санхүүжилтийн олон

төрлийн арга хэрэгслийг ашигладаг. Манай улсын хувьд ХАА-н бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн төрөөс хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр болон сангуудын санхүүжилтээс гадна олон улсын байгууллага болон банкны салбар чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зураг 12. ХАА-н салбарын бизнес эрхлэгчдэд олгож буй санхүүжилтийн эх үүсвэр



Эх сурвалж: ХАА-н салбарын санхүүжилтийн стратегийг загварчлах нь судалгаа, 2023

Хөдөө аж ахуйг дэмжих сан

МУ-ын ЗГ-ын 1999 оны 37-р тогтоолоор “Буудай сан” болгон өөрчлөн сангийн үйл ажиллагааг анхлан эхлүүлсэн байдаг. Харин 2005 онд МУ-ын засгийн газрын 139-р тогтоолоор “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” болгон өөрчлөн УИХ-аас баталсан “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд заасны дагуу үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрийг эрчимжүүлэх, тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулах болсон. 2020 онд МУ-ын засгийн газрын 16 дугаар тогтоолоор “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г “Мал хамгаалах сан”-тай нэгтгэн “Хөдөө аж ахуйг дэмжих сан” болгосон бол 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр тус хуульд нэмэлт өөрчлөлт хийж тус санг засгийн газрын тусгай сангийн хуулиас хассан байна.

Тус сангийн хэчнээн хэмжээний санхүүжилтийг ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй этгээдэд олгосон талаарх мэдээлэл дутмаг бөгөөд Цахим, хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудсанд ерөнхий мэдээллийг оруулсан байна. Тус мэдээллээс харахад нийт 9,378 зээлдэгчдэд 183.9 тэрбум төгрөгийн зээл олгосноос 57 хувь нь иргэнд, 37.5 хувь нь аж ахуй нэгжид олгожээ. “Мал хамгаалах сан” нь дангаараа үйл ажиллагаа явуулж байхдаа 21.4 тэрбум орчим төгрөгийн зээл олгосноос 20.8 орчим нь буюу 97 хувь нь зээлээ эргэн төлөөгүй байна.

Зураг 13. ХАА-г дэмжих сангаас олгосон зээлийн мэдээлэл



Эх сурвалж: shilen.gov.mn

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

УИХ-аас 2007 онд “Жижиг дунд үйлдвэр”-ийн тухай хуулийг анхлан баталж, үүний хүрээнд “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, ЖДҮ-ийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг хангах зорилгоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-г үүсгэн байгуулсан. Тус сан нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш 1,011 тэрбум төгрөгийн зээлийг 8,403 төсөл, хөтөлбөрт санхүүжүүлжээ. Зээлийн 15 хувь нь буюу 151.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл чанаргүй байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас зээл авагчдын ихэнх нь хүнс, боловсруулах үйлдвэр зэрэгт хөрөнгө оруулалт хийх зорилгоор санхүүжилтийг авчээ. Сангийн үйл ажиллагаа нь бусад сангуудын үйл ажиллагаатай харьцуулахад тоон мэдээлэл нь нээлттэй, дагаж мөрдөх журам, дүрэм нь тодорхой байгаа нь давуу талтай байна.

Зураг 14. ЖДҮ-г хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээлэл



Эх сурвалж: ЖДҮ-г дэмжих сангийн цахим хуудас

Бусад сангууд болон олон улсын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр

“Сум хөгжүүлэх сан”, “Хоршоог хөгжүүлэх сан”, “Орон нутгийн хөгжлийн сан” зэрэг сангуудыг улсын төсөв болон олон улсын байгууллагуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл зэргээр санхүүжүүлж хөдөө, орон нутагт ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг чадавхжуулах, тэдний үйлдвэрлэлийг дэмжих, тогтвортой ажлын байраар хангах, сургалтад хамруулан чадавхыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авдаг ч хэчнээн хэмжээний санхүүжилт хийгдсэн, хэр үр дүнтэй хэрэгжсэн талаарх мэдээлэл хомс байдаг. Нөгөө талаас ХАА-н бизнес эрхлэгчид нь мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан өөрт хэрэгцээтэй хөрөнгө оруулалт, санхүүжилтийг авч чадахгүй байгаа нь судалгааны явцад харагдаж байна.⁴

Сүүлийн жилүүдэд “Зээлийн батлан даалтын сан” нь хүнсний болон ХАА үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр идэвхтэй ажиллах болсон. Тухайлбал, хүнсний гол нэрийн 19 төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр зээлийн батлан даалт гаргаж байна. Мөн Жайка төслийн зээл, Монголбанкны Репо санхүүжилтийн зээл зэргийг нийтлэг ашигладаг байна.

Санхүүгийн түрээсийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль нь ХАА-н салбарын хөгжилд томоохон дэвшлийг авчирч буй. Тухайлбал, Санхүүгийн түрээсийн хуулийн хүрээнд томоохон санхүүгийн байгууллагууд ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдэд техник, технологийн шийдэл, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг олгожээ. Харин Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн хэрэглээ санхүүгийн байгууллагуудын дунд дутмаг байгаа хэдий ч энэ хуулийн хүрээнд ХАА-н бизнес эрхлэгчид барьцаа хөрөнгийн дутагдлыг тодорхой хэмжээнд шийдээд явж байна. Мөн сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ ХАА-н бизнес эрхлэгч нарт ногоон зээл, богино хугацааны эргэлтийн хөрөнгийн зээл зэргийг олгоод явж байна.

Арилжааны банкнууд

Арилжааны банкнууд нь ХАА-н салбарыг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийг хэд хэдэн төрлөөр олгож байна. Нэгдүгээрт, өөрийн эх үүсвэрээр ХАА-н бизнес эрхлэгч нарт эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл, ногоон зээл гэх зэрэг зээлийг нийтлэг олгож байгаа бөгөөд дээрх зээлүүдийг сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 1.2-1.5 хувийн хүүтэйгээр, зээлийн дундаж хугацаа нь 2-3 жил бөгөөд зээлийн эргэн төлөлт болон чанаргүйдэл харьцангуй бага байжээ. Дээр нь тус салбарт банкны салбарын нийт зээлийн 2-3 орчим хувь л олгогддог. Хоёрдугаарт, төрийн зүгээс авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж хөнгөлөлттэй зээлийг олгож байна. Тухайлбал, 2023 онд л гэхэд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд 5-6 хувийн хүүтэй 934 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 1,957 этгээдэд олгосон бөгөөд хүүгийн зөрүүг улсын төсвөөс төлсөн. Гуравдугаарт, томоохон банкнуудын

⁴ “ХАА-н суурь судалгаа”-ны ярилцлагын шатанд энэ талаар дурдсаныг өмнөх бүлэгт оруулсан.

өртгийн сүлжээний санхүүжилтийн арга хэрэгслүүдийг ашиглан ХАА-н зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж ажиллаж байна.⁵ Дөрөвдүгээрт, олон улсын банк санхүүгийн байгууллагаас тусгай зориулалтын хүрээнд санхүүжилт авч түүнийг ХАА-н болон бусад салбарын бизнес эрхлэгч нарт зээл хэлбэрээр олгодог. Ийнхүү доорх зурагт арилжааны банкууд хэрхэн ХАА-н салбарт санхүүжилт олгож буй байдлыг ерөнхийд нь зураглан харуулъя.

Зураг 15. Банкны салбарын санхүүжилт



Эх сурвалж: Төслийн хүрээнд хийгдсэн судалгаануудын тайланд дурдсан мэдээллүүдийг нэгтгэн боловсруулав.

⁵ "ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа"-нд манай улсад амжилттай хэрэгжиж буй өртгийн санхүүжилтийн арга хэрэгсэл, түүнийг амжилттай хэрэгжүүлсэн банкуудын талаар дурдсан.

Нэг талаас ХАА-н бизнес эрхлэгч нарыг дэмжихэд чиглэсэн олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрүүд байгаа боловч тус салбарын бизнес эрхлэгчид хэрэгцээтэй санхүүжилтийг авч чадахгүй байгаа нийтлэг хүндрэл бэрхшээл нь дараах байдалтай байна. (Эрэлтийн талд тулгамдаж буй асуудал). Үүнд:

- Барьцаа хөрөнгийн дутагдал
- Зээлийн нөхцөл хатуу, бичиг баримт бүрдүүлэлт төвөгтэй
- Батлан даалтад хамрагдаж чадахгүй байх
- Төсөл, хөтөлбөр болон бусад санхүүжилтийн боломжийн талаар мэдээлэл дутмаг байдал
- Санхүүгийн мэдлэг, чадвар дутмаг
- Зах зээлийн судалгаа, бизнес төлөвлөгөө хийдэггүй
- Агуулах, тээвэрлэх, хадгалах гэх мэт дэд бүтцийн дутагдал

Нөгөө талаас томоохон санхүүжилтийн эх үүсвэр болох банкнуудад дараах хүндрэл бэрхшээл тулгардаг тул ХАА-н бизнес эрхлэгчдэд зээл олгоход төвөгтэй байдаг (Нийлүүлэлтийн талд тулгамдаж буй асуудал). Үүнд:

- Барьцаа хөрөнгийн дутагдалтай байдал
- Салбарын тоон мэдээлэл хязгаарлагдмал
- ХАА-н салбарын дэд бүтэц, салбар хоорондын хамаарал сул
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын уялдаа холбоо, оролцоо сул
- ХАА-н бизнес эрхлэгчид гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл учирдаг
- Гадаадын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд бага
- Макро эдийн засаг, нийгмийн байдал болон хууль, эрх зүйн орчноос хамааран санхүүжилтийн хэмжээ жил бүр тогтмол байх эсхүл олон улсын байгууллагаас нэмэлт санхүүжилт татахад ихээхэн хүндрэлтэй.


Дээр дурдсан асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх боломжгүй бөгөөд хамгийн оновчтой, олон улсад амжилттай хэрэгжиж буй сайн туршлагад үндэслэн санхүүжилтийг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулан, бодлогын арга хэмжээг шат дараатайгаар авах нь зүйтэй. ХАА-н салбар нь стратегийн шинж чанартай буюу экспортын гол бүтээгдэхүүн, эсхүл импортын орлох бүтээгдэхүүн дээр төр, хувийн хэвшил, санхүүгийн байгууллагууд болон бусад институт хамтран нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийн арга хэрэгслийг түгээмэл ашигладаг. Манай улсын хувьд нэмүү өртгийн сүлжээний санхүүжилт гэдэг ойлголт нь аль хэдийн шинэлэг ойлголт биш болсон. Тухайлбал, томоохон банкнуудын хувьд сүү, ноолуур зэрэг ХАА-н бүтээгдэхүүн дээр нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийг хэрэгжүүлэн тодорхой хэмжээнд бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тухайн сүлжээнд оролцож буй бүхий л талуудад санхүүжилтийн дэмжлэгийг үзүүлэн төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлээд явж байна.⁶ Асуудал нь нэмүү өртгийн сүлжээний тухай ойлголтыг банкнууд болон ХАА-н бизнес эрхлэгч нар мэдээд буй хэр нь үр ашигтай, хүртээмжтэй санхүүжилтийг ХАА-н бизнес эрхлэгч нарт яагаад олгохгүй байна вэ? Нөгөө талаас ХАА-н бизнес эрхлэгч нар нь нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийн талаар ойлголттой хэдий ч яагаад өөрт хэрэгцээтэй санхүүжилтийг авч чадахгүй байна вэ? гэдгийг цаашид тодруулах, түүнд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

6 "ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа"-ны хэлэлцүүлгийн үр дүнд хэд хэдэн банкууд өртгийн сүлжээний санхүүжилтийг амжилттай хэрэгжүүлээд явж байна.

2.3. ХАА-н салбарын санхүүжилтийн боломжит гарц шийдэл

Нэмүү өртгийн сүлжээний санхүүжилт гэдэг нь энгийнээр үйлдвэрлэлийн үе шатаас эцсийн хэрэглэгч хүртэлх бүхий л шат дамжлагын тоон мэдээлэл дээр тулгуурлан тухайн сүлжээнд оролцогчдод оновчтой санхүүжилтийг олгохыг хэлж болно. ХАА-н салбар өндөр хөгжсөн зарим улс орнуудад хэрхэн тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн үйл ажиллагааг дэмждэг, санхүүжилтийн ямар механизм ашигладаг зэрэг судалгааг хийж гүйцэтгэн манай улсад хэрэгжих боломжтой ХАА-н салбарын санхүүжилтийн загварчлалыг гаргасан. Манай улсын хувьд ХАА-н бизнес эрхлэгчдийн дийлэнх нь бүтээгдэхүүнээ орон нутгийн борлуулагчид худалдах, орон нутгийн борлуулагч нь хотод өөр нэг томоохон борлуулагчид худалдах, эсхүл захууд болон хүнсний хөнгөн үйлдвэрүүдэд нийлүүлэх зарчмаар ажиллаж буй бөгөөд ашгийн дийлэнх хэсгийг дээрх сүлжээнд оролцогчдын дундаас борлуулагч нар хүртэж буй нь харагдсан. Энэхүү загварыг өөрчлөхөд нэлээн төвөгтэй бөгөөд худалдааны давуу тал нь тухайн борлуулагч нарт түлхүү олгогдсон буюу тухайн шат дамжлага бүрийн борлуулагч нь тухайн бүс нутагтаа санхүүгийн хувьд чадамжтай, агуулахтай, тодорхой хэмжээний борлуулалтын сувагтай тул зах зээлийн үнэ тогтоох бүрэн чадамжтай байдаг. Ийнхүү ХАА-н салбарт бизнес эрхэлж буй этгээдэд банкны зүгээс эсхүл олон улсын төсөл, хөтөлбөрийн зүгээс санхүүжилт олгоход барьцаа хөрөнгө болон тоон мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан санхүүжилтийг хүртээмжтэй олгоход ихээхэн хүндрэл учирдаг. Санхүүжүүлэгч байгууллагуудын хувьд нэмүү өртгийн сүлжээний мэдээлэлд тулгуурлан санхүүжилт олгохоос илүүтэйгээр өөрсдийн тоон мэдээлэлд тулгуурлан ХАА-н чиглэлээр бизнес эрхлэгч нарт санхүүжилт олгож буй нь тухайн бизнес эрхлэгч нарын хүссэн хэмжээтэй нийцэхгүй байгаа юм. Тухайлбал, нэгдсэн тоон мэдээлэл байхгүй тул санхүүжилт ямар нэг арга хэрэгсэл ашиглахаас илүүтэйгээр барьцаа хөрөнгө шаардах, бизнесийн үйл ажиллагаа нь тогтмол явагдаж буй эсэхийг шалгах зэрэг асуудлууд ихээхэн тулгардаг.

Зураг 16. МУ-н ХАА-н салбарын санхүүжилтийн зураглал



Эх сурвалж: ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа, 2023

Иймд ХАА-н бизнес эрхлэгчид нь тухайн бүсэд ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдтэй тодорхой хэмжээнд хамтрах, хорших замаар анхан шатны болон дундын хоршоог бий болгох замаар тээвэр логистик, үйл ажиллагааны зардлыг хэмнэхээс гадна тодорхой хэмжээний санхүүжилтийг тухайн байгууллагаар дамжуулан банкнаас авах боломжтой болох юм. Нөгөө талаас санхүүжилтийг олгож буй банк нь агуулах, тээвэр логистикийг гүйцэтгэж буй этгээдэд эргэлтийн хөрөнгийн санхүүжилт олгох, цаашлаад өртгийн сүлжээг буй болгож буй оролцогч талуудын тоон мэдээлэл, гэрээний үндсэн дээр зээл олгох замаар дэмжээд явах бүрэн боломжтой. Дээрх санхүүжилтийн боломжоос гадна ХАА-н чиглэлээр ажиллаж буй бизнес эрхлэгч тус бүр нь нэмүү өртгийн сүлжээнд тодорхой хэмжээнд оролцох боломжийг буй болгосноор тоон мэдээлэл үүсэх, цаашлаад бизнесийн үйл ажиллагаа өргөжихөд дөхөм болох юм. Дээр нь томоохон онлайн дэлгүүр, платформ болон сүлжээ дэлгүүрүүд ХАА-н бизнес эрхлэгч нартай хамтран ажилласнаар үйлдвэрлэгчээс хэрэглэгч рүү шууд хүргэх нэмүү өртгийн сүлжээг буй болгох боломжтой. Ийнхүү талууд хэрхэн тухайн өртгийн сүлжээнд оролцож буйг баталгаажуулан гэрээ байгуулах, холбогдох мэдээллээ хоорондоо хуваалцах, бүртгэлийн системийг буй болгосноор тодорхой хугацааны дараа гэрээг үндэслэн банкнууд зээл олгох боломжтой юм.⁷ Өөрөөр хэлбэл банк ХАА-н бизнес эрхлэгчид нь хаана, ямар төрлийн бизнес эрхлэн, хэрхэн хэрэглэгчдэд ямар үнээр зарж буй талаарх бүхий л мэдээлэлтэй болох юм. Иймд дээрх мэдээлэлд тулгуурлан санхүүжилтийг олгон хүртээмжийг нэмэгдүүлнэ. Энэхүү загварчлал үр ашигтай, хүртээмжтэй ажиллахад төрийн оролцоо чухал үүрэгтэй. Тухайлбал, одоо нэвтрүүлж буй газрын бүртгэл, бүтээгдэхүүний бүртгэлийн системүүдийг банкнууд болон оролцогч талууд авч ашиглах бүхий л боломжоор хангаж өгөх, дээр нь банкнуудын гаргасан зээлийн бүтээгдэхүүний тодорхой хэсгийн эрсдэлийг хуваалцах хууль, эрх зүйн орчин буй болгохоос гадна бусад санхүүгийн байгууллагуудыг татан оролцуулахад ихээхэн хичээл зүтгэл гаргах шаардлагатай юм.

ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийг үйл ажиллагааны онцлогоос хамааруулан олон талаас нь судалсан судалгаанууд цөөнгүй байна. Дээрх судалгаануудаас харахад ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтэд дараах хүндрэл бэрхшээл хамгийн ихээр тулгардаг. Санхүүгийн байгууллагуудын хувьд ХАА-н бизнес эрхлэгчдийн талаар мэдээлэл хомс, мэдлэг дутмаг байгаа тул барьцаа хөрөнгө шаарддаг талаар дурдсан бол нөгөө талдаа ХАА-н бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж хэвшээгүй, санхүүгийн мэдлэг дутмаг байгаа зэргээс шалтгаалан санхүүгийн байгууллагуудаас хүссэн хэмжээний санхүүжилтийг авахад хүндрэл учирдаг болох нь харагдсан. Дээр нь ХАА-н салбарын дэд бүтэц муу, хоорондын хамаарал сул, мэдээллийн бааз үүсээгүй байгаа нь санхүүжилт олгоход ихээхэн хүндрэлтэй байдаг.

⁷ Хэд хэдэн банкнуудын хувьд дээрх мэдээллийн санг бүрдүүлэн тодорхой хэмжээнд амжилттай санхүүжилт олгоод явж байна.

Зураг 17. ХАА-н нэмүү өртгийн санхүүжилтийн сүлжээнд тулгамдаж буй асуудал



Эх сурвалж: ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа, 2023

ГУРАВ. ХАА-Н БИЗНЕСҮҮДИЙН ТЭЛЭХ ХӨГЖИХ БОЛОМЖУУД

Ийнхүү манай улсын хувьд ХАА-н бүтээгдэхүүний онцлог шинж чанараас шалтгаалан төмс хүнсний ногоо, үр тариа тэжээл, мах махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүний гэсэн нэмүү өртгийн сүлжээг тодорхой хэмжээнд бүрдүүлээд явж байна. Ийнхүү нэмүү өртгийн сүлжээнд нэгдсэн ХАА-н бизнес эрхлэгчдийн хувьд тодорхой хэмжээнд санхүүжилтийн эх үүсвэрийг банк болон бусад санхүүгийн байгууллагуудаас авах боломж нь илүү өндөр бөгөөд үйлдвэрлэлтэй холбоотой тоон мэдээлэл болон бусад холбогдох бүртгэлүүд үүсэж байгаа нь давуу тал болдог. Нэмүү өртгийн сүлжээ нь үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан олон төрөл байх боловч эцсийн дүндээ олон оролцогч талуудаас бүрдсэн сүлжээнд нэгдэх нь ХАА-н бизнес эрхлэгч нарт илүү үр ашигтай. Дараах арга хэрэгслүүдийг ашиглавал ХАА-н бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа өргөжих боломжтой нь судалгаануудын үр дүнгээс харагдаж байна./Макро түвшнээс эхлэн нарийвчлан харууллаа/ Үүнд:

1. ХАА-н салбарт олгох зээл, санхүүжилтийн тохиромжтой эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

- ХАА-н салбарт урт хугацааны гаднын зээл, санхүүжилтийг татах, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бүрдүүлэх.
- Агуулахын санхүүжилтийг ашиглан ХАА-н бизнес эрхлэгч нарт олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын (ЭЗБТУАСА) дагуу ХАА-н салбарын ангилалд ХАА-н салбараас гаралтай түүхий эд боловсруулах, бэлтгэн нийлүүлэх, мөн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулахтай холбоотой үйл ажиллагааг оруулан ангилдаг болох. Ингэснээр ХАА-н салбарын нэмүү өртгийн/ нийлүүлэлтийн сүлжээний бүх гол оролцогчдыг оруулан салбарын үйлдвэрлэл, орц гарцын талаарх бүрэн дүүрэн мэдээлэлтэй болох боломжтой болно.
- Хөтөлбөрийн эх үүсвэрүүдийн нөхцөл, хугацааг сайжруулах. Өөрөөр хэлбэл төсвийн тухай хэлэлцэж дуусахтай зэрэгцэн ирэх онд тус салбарт хэдий хэмжээний санхүүжилтийг ямар нөхцөлтэйгөөр хэнд, хэрхэн олгох талаар мэдээллийг ил тод болгох.
- Репо санхүүжилтийн ашиглан тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд богино болон дунд хугацааны зээлийн санхүүжилтийг олгох.

2. ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон өртгийн сүлжээнд оролцогч талуудын хооронд мэдээллийн урсгалыг сайжруулах, холбох үүнд технологийн шийдлийг ашиглах.

- Хөнгөлөлттэй зээлүүдийн зориулалтыг салбарыг дэмжих баримт бичгүүдтэй холбон уялдаа холбоог сайжруулах, түүнчлэн эх үүсвэрийн олголтын хугацааг бизнесийн шинж чанартай нь уяах зэрэг төрийн байгууллагууд менежментээ сайжруулах.

- Зээлдэгчийн мэдээллийн сан үүсгэж, түүх бий болгоно гэдэг нь банкнуудын хувьд цаг хугацаа их шаарддаг ба ялангуяа жижиг болон дунд банкнуудын хувьд энэ салбарын суурь дата мэдээлэл хомс байна. Иймд холбогдох яам, агентлагууд мэдээллийн урсгалаа сайжруулах, бүртгэлийн системийг үнэн бодитоор үүсгэх, мэдээллээ цахимаар хуваалцах.
- Зээл санхүүжилт болон авлагын цахим платформыг хөгжүүлэх, технологийн компаниудыг дэмжих. Төрийн мэдээллийн санг нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах, тухайлбал нийлүүлэлтийн сүлжээнд plant.mofa.gov.mn, [ebarimt](http://ebarimt.mpr.gov.mn) зэрэг бүртгэл, санхүүгийн системийг, mpr.gov.mn-г хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлд ашиглах.

3. Зээлийн эрсдэлийг бууруулахад төрийн оролцоог нэмэгдүүлэх

- Зээлийн батлан даалтын сантай /ЗБДС/ хамтын ажиллагааг сайжруулах, ХАА-н салбарын хөдлөх хөрөнгө барьцаалсан/ өртгийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүнд зориулсан батлан даалтын шинэ бүтээгдэхүүн гаргах боломжийг судлах. Ойлголцлын зөрүүг арилгах, ЗБДС-ийн үйл ажиллагааг улам эрчимжүүлэхэд анхаарлаа хандуулах.
- Зээлийн эрсдэлийг даатгах даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх талаар даатгалын салбартай хамтран ажиллах, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний ач холбогдлыг гол оролцогч талуудад таниулж, ойлгуулах хугацааны даатгалын төлбөрийн тодорхой хэсгийг ЗГ-аас санхүүжүүлэх.
- ХАА-н салбарын хөдлөх хөрөнгө барьцаалсан/ өртгийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүнд зориулсан эрсдэл хуваах механизмыг хөгжүүлэх боломжийг судлах. ЗГ-аас энэ салбарт олгож буй дэмжлэг, урамшууллын тодорхой хэсгийг энэ зорилгоор ашиглах. Ингэснээр зах зээлийн зарчмаар салбарыг цаашид урт хугацаанд хөгжих боломжийг бүрдүүлэхэд томоохон дэмжлэг болно.
- Мөн санхүүгийн салбарт, ялангуяа ХАА-н санхүүжилтийн чиглэлээр ажиллах сонирхолтой гаднын байгууллагуудын дэмжлэгийг энэ зорилгод чиглүүлэх.
- Нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхгүй байх нь зээлийг эрсдэлтэй болгох нэг чухал хүчин зүйл болдог тул үүнийг бууруулах, багасгахад тухайн оролцогч талын зээлийн эрсдэлийг үнэлдэг системийг нэвтрүүлэх, зээлийн эрсдэлийн талаарх мэдлэг, мэдээллийг ХАА-н бизнес эрхлэгчдэд ойлгуулах.

4. ХАА-н бизнес эрхлэгчдийн нэмүү өртгийн сүлжээ болон санхүүжилтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах.

- Хаана хэрхэн нэмэгдэл өртөг үүсэж буй талаар мэдээлэл байхгүй байгаа нь зах зээлд оролцогч талуудын дунд тодорхой бус байдлыг үүсгэж буй тул нэгдсэн систем, бүртгэлийг сайжруулах.
- Хууль, эрх зүйн талаарх мэдлэг, тэр дундаа хөдөлмөрийн харилцаа, зохицуулалт болон гэрээний үүргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.
- Бараа материал, нөөцийн бүртгэл, бизнес төлөвлөлтийг илүү сайн

хөтлөхөд анхаарах.

- Олон улсын чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлтэд чиглэсэн санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө авах.
- Үйл ажиллагаа явуулж буй газар, нутгийн хүрээнд ХАА-н бизнес эрхлэгчид хоорондоо нэгдэх, хамтран агуулах болон тээвэрлэлтийн асуудлаа шийдвэрлэхэд анхаарах.

5. ХАА-н салбарын үйл ажиллагаатай холбоотой банкнуудын ойлголт мэдээллийг сайжруулах.

- ХАА-н салбарын бизнесийн үйл ажиллагааны онцлог, гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой анхаарах асуудлуудын талаарх нарийн техникийн сургалтуудыг салбарын мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах, гарын авлага, заавар зөвлөмж боловсруулах.
- Нөгөө талаар зөвхөн банк санхүүгийн байгууллагуудад чиглэсэн сургалтын үйл ажиллагаанаас гадна ХАА-н салбарын бизнес эрхлэгчид, зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах, бизнесийн ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ техник технологийг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах.
- ХАА-н салбарт мөрдөгддөг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн стандарт, шаардлага, дүрэм, журам, мөн сүүлийн үеийн, ялангуяа байгаль орчинд ээлтэй шинэ техник технологи ашиглалтын талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулах, байнга шинэчилж байх холбогдох суваг, бүтцийг банкны салбарт хөгжүүлэх.

Эцэст нь хэлэхэд энэхүү салбарын хөгжил нь нэмүү өртгийн сүлжээ туунд тулгуурласан санхүүжилтийн арга хэрэгслүүдийг ашиглан үр ашигтай санхүүжүүлэх замаар хөгжихөөс гадна тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдийн хичээл зүтгэл, хамтын ажиллагаанаас ихээхэн хамаардаг.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

BEST хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ХАА-н суурь судалгаа, ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа болон ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь судалгаануудын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

ХАА-н салбарын бизнес эрхлэгчид нь нэг төрлийн үйл ажиллагаа эрхлэхээс илүүтэйгээр бизнесийн үйл ажиллагаа, бүс нутгийн онцлог зэргээс шалтгаалан хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа хавсран гүйцэтгэдэг. ХАА-н бизнес эрхлэгчид нь үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь үйл ажиллагаа тасралтгүй, тогтвортой явуулахад чухал ач холбогдолтой нь харагдаж байна. Дээр нь сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлт, нөхцөл байдлаас шалтгаалан тус салбарт тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулахад ихээхэн хүндрэл учирч байна. ХАА-н бизнес эрхлэгчид нь бизнесийн үйл ажиллагааг төрөлжүүлэх, тэлэх, хөгжүүлэхэд санхүүжилт, техник тоног төхөөрөмж болон хүний нөөцийн хэрэгцээ шаардлага өндөр байна.

Мөн тус салбарын бизнес эрхлэгчид нь улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг тул агуулах, тээвэрлэлт логистикийн хүндрэлтэй байдал нь дундын борлуулагч/зуучлагч нарт ихээхэн ашиг хүртэх боломжийг олгож байна. Нэмүү өртгийн сүлжээг сайжруулах, түүнд тулгуурласан санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглахын тулд ХАА-н бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс эхлээд хэрэглэгчдэд хүрэх хүртэл бүхий л шатанд оролцох оролцогчдыг тодорхой болгох, тэдгээрийн мэдээллийг ил тод болгох, цаашлаад мэдээллийг ашиглах, хуваалцах тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна. Дээр нь дан ганц банкны салбар санхүүжилтийн арга хэрэгслийг нэвтрүүлэхэд анхаарлаа хандуулахаас илүүтэйгээр санхүүгийн бусад байгууллагуудын оролцоог дэмжих, шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдүүлэхэд төрийн зүгээс анхаарч ажиллах, төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна. ХАА-н бизнес эрхлэгч нарт санхүүгийн боловсролоос гадна гэрээний хариуцлага, хууль эрх зүйн орчин болон бусад шаардлагатай сургалт, мэдээллийг тогтмол олгох хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Нэмүү өртгийн сүлжээнд оролцохын зэрэгцээ ХАА-н бизнес эрхлэгчид нь бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагааны онцлог шинж чанараараа нэгдэн өөрсдийн зардлыг бууруулах, нэгдсэн байдлаар тээвэр, агуулахын асуудлаа шийдвэрлэх, цаашлаад зах зээлд гаргахдаа нэгдмэл байдлаар оролцох зэрэг нь үр ашгийг нэмэгдүүлэхээс гадна, эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулах боломжтой нь харагдаж байна. Дээр нь нэмүү өртгийн сүлжээнд тодорхой хэмжээнд нэгдсэн бол гэрээний үүргийг биелүүлэх, нийлүүлэлтийг тасралтгүй байлгахад ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Борлуулалт, маркетинг болон менежментийн тал дээр нэгдсэн байдлаар мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээг авч ажиллавал урт хугацаандаа бизнесийн үйл ажиллагаа тогтворжих, зах зээлд тодорхой хэмжээнд тоглолт хийх боломжтой байна.

ХАА-н бизнес эрхлэгчид нь бүтээгдэхүүний чанар, эрүүл аюулгүй байдалд ихээхэн анхаарлаа хандуулж, чанарын бүртгэлийг хийх, цаашлаад олон улсын чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэхэд боломжийг судлах хэрэгтэй байна. Учир нь манай улсын хэмжээнд олон улсын стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлж буй ХАА-н бизнес эрхлэгчид цөөн байгаа тул дотоодын зах зээлээс цааш гарах тэлэх боломжгүй байдалд хүргэж байна. Мөн ХАА-н эрүүл мэндийн чиглэлээр суралцах, мэргэжлийн зөвлөгөө авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлага өндөр байгаа нь харагдаж байна.

Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангахад ихээхэн анхаарал хандуулах шаардлагатайгаас гадна бүс нутгийн хэмжээнд агуулах, тээвэрлэлтийн хүндрэлийг шийдвэрлэх цаашлаад хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих, нэмүү өртгийн сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэлд анхаарал хандуулж ХАА-н бизнес эрхлэгчдийн тогтвортой, тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна. Мөн нэмүү өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн арга хэрэгслүүдийг ашиглахад хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг авч салбар хоорондын уялдаа холбоог хангахад чиглэж ажиллах нь зүйтэй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

BEST хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ХАА-н суурь судалгаа, ХАА-н салбарын санхүүжилтийн судалгаа болон ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь судалгаануудын үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

№	Нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талууд	Зөвлөмж саналууд
1	ХАА-н бизнес эрхлэгчид	- Олон улсын чанарын баталгаажуулалт, стандарт нэвтрүүлэлтэд чиглэсэн санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа авч өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. Эрүүл аюулгүй ХАА-н бизнес үйлдвэрлэх цаашлаад цаг уурын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох талаар сургалтад хамрагдах - Үр ашигтай технологи, төхөөрөмжийг ашиглах, чадварлаг хүний нөөцийг сургаж бэлдэх талаар бодлогын шинж чанартай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх - Түүхий эдийн болон үйлдвэрлэлийн нөөцийн бүртгэл, дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх төлөвлөлтийг сайн хөтлөх, энэ талын мэргэжлийн зөвлөгөөг тогтмол авч хэвших - Бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах, зардал хуваалцах, нөөцийг үр ашигтай ашиглахад ихээхэн анхаарлаа хандуулах
2	Өрх, хоршоод	- Санхүүгийн болон хууль эрхзүйн мэдлэгээ сайжруулах - Нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын оролцоо, хамтран ажиллах боломж, цаашлаад хэрхэн үр ашигтай ажиллах боломжтой талаар нэгдсэн ойлголт, сургалтад хамрагдах - Борлуулалт, агуулах, тээвэрлэлт болон санхүүтэй холбоотой асуудлыг хамтарч шийдэх, технологийн шинэчлэлийг хамтран зардал хуваалцах зарчмаар шийдвэрлэх. Мөн хоршоодын гишүүдийн бүтээгдэхүүний бүртгэлийн системийг хөгжүүлэх, түүнд тулгуурлан нөөцийн хуваарилалтыг оновчтой хийх - Хоршооны гишүүдийг чадавхжуулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, менежментийн багийг зөв бүрдүүлэхэд мэргэжлийн туслалцаа авах - ХАА-н зохистой дадлын талаарх мэдлэгээ сайжруулах

3 ХАА-н бирж	• Биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, өргөжүүлэх, үр өгөөж хүртээмжийг нэмэгдүүлэх • Үүнд чиглэсэн бодлогыг тодорхойлох, цаашлаад хууль эрх зүйн орчныг сайжруулж ил тод, нээлттэй шударга өрсөлдөөнийг бий болгох • Томоохон худалдан авагчдыг биржээр худалдан авалт хийх боломжийг бүрдүүлэх, ил тод нээлттэй байх боломжоор хангах
4 Судалгааны байгууллагууд	• Нэмүү өртгийн сүлжээн дэх оролцогч талуудын үүсгэж буй нэмэгдэл өртгийг тодорхойлоход чиглэсэн дараагийн шатны судалгаануудыг хийх • Үр дүнд үндэслэн нэмүү өртгийн сүлжээн дэх сайжруулах боломжтой чиглэлүүдийг тодорхойлж агуулах, тээвэрлэлт, эсхүл үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломж, шинэ технологид хөрөнгө оруулалт хийх бодлогын шинж чанартай шийдвэрүүдийг гаргах • Нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын харилцан уялдаа холбоо, хамтран ажиллах арга хэлбэрийг нарийн тодорхойлох. Тухайлбал, нэмүү өртгийн сүлжээг бүхэлд нь хэрхэн уялдуулж ажиллуулах боломжтойг тодорхойлох
5 Санхүүгийн байгууллагууд	• Нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийн арга хэрэгслийг ашиглан ХАА-н бизнес эрхлэгч нарт санхүүжилт олгоход анхаарлаа хандуулах • Зээлийн эдийн засагчдын ХАА-н салбарын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эсхүл мэргэжлийн зөвлөх байгууллагуудтай хамтран ажиллах • Санхүүгийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, ойлголцлын зөрүүг арилгах • Төрд буй мэдээллийг ашиглах, технологийн шийдлийг ашиглан санхүүжилт олгох боломжийг бүрдүүлэх
6 Төрийн байгууллагууд	• Төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах • Хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох тал дээр дэмжлэг үзүүлэх • Төрийн мэдээллийг ил тод олон нийтэд ашиглуулах • Технологийн дэвшлийг ашиглахад дэмжлэг үзүүлэх • Сангийн зээлийн шалгуур болон зээл олголтын талаарх мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх • Хөнгөн боловсруулах үйлдвэрүүд болон тээвэр, логистикийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг авч ажиллуулах

НОМ ЗҮЙ

Battulga Jamsranjav and Buyannemekh Puntsagdorj. (2021). ХААБ-ээр хүнсний улаан буудай дамжуулан худалдаалах дериватив зах зээлийн судалгаа.

Байгаль орчин, х. а. (2023). ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь.

Байгаль орчин, х. а. (2023). ХАА-н суурь судалгаа.

Банк, с. а. (2023). ХАА-н салбарын санхүүжилт.

УИХ. (2022). «Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим нэг арга хэмжээний тухай». Улаанбаатар.

ҮСХ. (2022). Ажиллах хүчний судалгаа.

ҮСХ. (2022). ХАА-н 2022 оны тооллогын нэгдсэн үр дүн.


ҮСХ. (2022). Хөдөлмөрийн салбарын танилцуулга.

ХХААХҮЯ. (2023). Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого, хэрэгжилт.

Хавсралт 1. Хүнсний ногооны бизнес загварын боломжит хувилбар

ХАА-н гол бүтээгдэхүүн болон хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний загварчлалыг мөшгөн судалсны үндсэн дээр дундын хоршоонд түшиглэсэн бизнес загварыг нэвтрүүлэх шаардлагатайг судалгаагаар тодорхойллоо. Энэхүү бизнес загварыг нэвтрүүлэн дундын хоршоонд түшиглэн өрхийн тариаланчид болон анхан шатны хоршоодыг нэгдсэн зохион байгуулалтад оруулснаар хүнсний ногооны өртгийн сүлжээнээс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Дундын хоршоонд түшиглэсэн бизнес хөгжлийн загварын ерөнхий зураглалыг Зураг 18-с харна уу. Дундын хоршооны үндсэн бүтэц, үндсэн үйл ажиллагаа: Хүнсний ногооны тариалан эрхлэгч өрх нь анхан шатны хоршооны зарчмаар ажиллах ба анхан шатны хоршоод нь дундын хоршоонд харьяалагдаж ажиллана.

Зураг 18. Дундын хоршоонд түшиглэсэн бизнес загвар (хүнсний ногоо)



Эх сурвалж: “ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээг үнэлэх нь” судалгаа

Мөн дундын хоршооны гишүүдэд үзүүлэх үндсэн үйлчилгээ, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Борлуулалт/зуучлалын үйлчилгээ: Дундын хоршоо нь өөрийн гишүүдийн хүнсний ногооны борлуулалт, маркетингтай холбоотой үйл ажиллагааг хариуцаж ажиллана.
- Агуулах, хадгалалтын үйлчилгээ: Дундын хоршоо нь өөрийн гишүүдийн хүнсний ногооны агуулах, хадгалалтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. Энэ нь өрхийн болон анхан шатны хоршоодыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах гол хөшүүрэг буюу хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн стратеги байх ба энэхүү арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлнэ.
- Машин, техникийн үйлчилгээ: Дундын хоршоо нь гишүүдийн түүхий эд, материалын татан авалт, хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалт болон борлуулалтын үеийн машин, техникийн хэрэгцээг зохион байгуулж ажиллана. Энэ нь дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний стратеги байх болно.
- Санхүүгийн үйлчилгээ: Дундын хоршоо нь мөнгөн хуримтлал, хөрөнгөд суурилан хоршооны гишүүдэд чиглэсэн санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээ үзүүлж ажиллах ба энэ нь дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний стратеги юм.

Дундын хоршоонд түшиглэсэн бизнесийн загварыг нэвтрүүлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний стратегийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Одоо байгаа дундын хоршоодыг чадавхжуулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, менежментийн багийг зөв бүрдүүлж, гишүүдэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг оновчтой болгоход дэмжлэг үзүүлэн ажиллах;
- Дундын хоршооны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн уулзалт хэлэлцүүлэг, богино хугацааны сургалтыг зохион байгуулах;
- Өрхийн түвшний болон анхан шатны хоршоодын ихэнх хувьд нь хүнсний ногооны хадгалалттай холбоотой агуулах, зоорины дутагдалтай байдал маш чухал тулгамдаж буй асуудал болоод байна. Иймд тариалан эрхлэгчдийн агуулах, зоорины асуудалд дэмжлэг үзүүлэн ажиллахад дундын хоршоог түшиглэн зохион байгуулж, тариалан эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах;
- Шинээр байгуулах дундын хоршоодын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, менежментийн багийг зөв бүрдүүлж, нэн тэргүүнд борлуулалт/зуучлалын үйл ажиллагаа болон агуулахын үйл ажиллагааг нь оновчтой хэрэгжүүлэхэд менежментийн зөвлөгөө өгч ажиллах;
- Дундын хоршоог гишүүдийн худалдан авалтын гэрээ барьцаалсан зээлийн санхүүжилт олж авах арга замыг эрэлхийлэн ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;
- Дундын хоршооны гишүүдийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх, үүнтэй холбоотой санхүүгийн байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллахад менежментийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- Тариалан эрхлэгчдийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтэй холбоотой санхүүжилтийн хэрэгцээг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллахад дундын хоршоог түшиглэн зохион байгуулах зэрэг арга хэмжээний стратегийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

